



ЧИНГИС ХААН  
БАНК



## ИНТЕРНЭТ БАНК ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА

*Ирээдүйд хөрөнгө оруулагч*

# АГУУЛГА


<b>1. ИНТЕРНЭТ БАНКАНД НЭВТРЭХ</b>	
1.1. Нэвтрэх.....	2
1.2. Нууц үгээ мартсан .....	3
<b>2. ЭХЛЭЛ</b>	
2.1. Дансны жагсаалт.....	4
2.2. Сүүлийн 5 гүйлгээ .....	5
2.3. Түгээмэл хийгддэг гүйлгээнүүд .....	5
2.4. Гүйлгээний загварууд .....	5
<b>3. ДАНС</b>	
3.1. Дансны жагсаалт.....	6
3.2. Хуулга авах.....	6
3.3. Зээлийн график.....	7
<b>4. ГҮЙЛГЭЭ</b>	
4.1. Өөрийн данс хооронд.....	8
4.2. Банк дотор.....	9
4.3. Банк хооронд.....	10
4.4. Гадаад шилжүүлэг .....	11
4.5. Зээл төлөх.....	12
4.6. Гүйлгээний түүх.....	13
<b>5. БҮТЭЭГДЭХҮҮН.....</b>	<b>13</b>
<b>6. ТОХИРГОО</b>	
6.1. Хувийн мэдээлэл.....	14
6.2. Нууц үг солих.....	14
6.3. Нууц асуулт солих.....	15
6.4. Хандалтын түүх.....	16
<b>7. ШУУРХАЙ ЦЭС.....</b>	<b>16</b>
<b>8. САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ .....</b>	<b>17</b>

## 1. ИНТЕРНЭТ БАНКИНД НЭВТРЭХ

Харилцагч та интернетэд холбогдсон дурын төхөөрөмжөөс [www.ebank.ckbank.mn](http://www.ebank.ckbank.mn) вэбсайтаар дамжуулан орон зай, цаг хугацаанаас үл хамааран интернэт банкны үйлчилгээг авч болно.

### 1.1. Нэвтрэх

Банканд бүртгүүлсэн и-мэйл хаяг, утасны дугаараар нэвтрэх нууц үг ирэх ба тэрхүү нууц үгийг ашиглан үйлчилгээнд нэвтэрнэ.




Энэ товч дээр дарж оруулсан нууц үгээ харах боломжтой.

*Санамж1: Таны компьютер интернет холбогдсон эсэхийг шалгах*

*Санамж2: Caps lock товч дарагдсан эсэхийг шалгах*

*Санамж3: Англи хэлний драйвер дээр байгаа эсэхийг шалгах*

Нэвтрэх нэр, нууц үгээ буруу оруулсан тохиолдолд автоматаар хариултгүй нууц асуулттай доорх цонх гарч ирнэ. Иймд та нэвтрэх нэр, нууц үгээ дахин шалган оруулах хэрэгтэй.




Нэвтрэх нэр, нууц үгээ буруу оруулсан тохиолдолд автоматаар гарч ирэх хариултгүй нууц асуултууд:

- Монгол улсын нийслэл?
- 1+1=?
- Гурвалжин хэдэн талтай вэ?

## 1.2. Нэвтрэх нууц үгээ мартсан тохиолдолд нууц үг дахин авах

Хэрвээ та нууц үгээ санахгүй мартсан бол “**Нууц үгээ мартсан**” товч дээр дарж нууц үгээ дахин банканд бүртгэлтэй и-мэйл хаягтаа хүлээн авах боломжтой.




< Буцах

Та бүртгэлтэй мэдээллээ оруулна уу:

Нэвтрэх нэр  И-мэйл хаяг

Та банканд бүртгэлтэй и-мэйл хаяг, регистрийн дугаараа зөв оруулснаар таны и-мэйл хаягт баталгаажуулах код ирнэ.



< Буцах

Та бүртгэлтэй мэдээллээ оруулна уу:


Нэвтрэх нэр  И-мэйл хаяг

и-мэйлээр очсон баталгаажуулах кодыг оруулна уу!

Баталгаажуулах кодыг оруулан **Баталгаажуулах** товч дээр дарснаар нэвтрэх нууц үг и-мэйл хаяг руу очино.

## 2. ЭХЛЭЛ


Эхлэл цэснээс та дансны жагсаалт, сүүлийн 5 гүйлгээ, түгээмэл хийгддэг гүйлгээнүүд, гүйлгээний загваруудыг нэг дороос харах боломжтойгоос гадна гүйлгээ хийж, хуулга харах боломжтой.



The screenshot shows the main interface of the Chingis Khaan Bank mobile app. At the top, there are navigation icons for Home, Accounts, Transactions, and Payments. The user's name 'Д. СОЛОНГО' and IP address 'Таны IP: 172.17.11.5' are displayed in the top right. The main content is divided into two sections: 'Дансны жагсаалт' (Account Balances) and 'Сүүлийн 5 И-Гүйлгээ' (Last 5 Transactions). The account balances section lists various accounts with their current balances. The transactions section shows a list of recent transactions with details like time, amount, and recipient. On the right side, there is a search bar and a list of frequently used accounts and transaction types.

### 2.1. Дансны жагсаалт

Дансны жагсаалт хэсгээс та өөрийн харилцах, хадгаламжийн дансны Боломжит үлдэгдэл, зээлийн дансны зээлийн үлдэгдлийг харах боломжтой.



This screenshot shows the 'Дансны жагсаалт' (Account Balances) section. It is divided into three categories: 'ХАРИЛЦАХ ДАНС' (Current Accounts), 'ХАДГАЛАМЖИЙН ДАНС' (Savings Accounts), and 'ЗЭЭЛИЙН ДАНС' (Loan Accounts). Each category contains a table of accounts with columns for account number, name, and balance. There are also icons for 'Дэлгэрэнгүй' (Details) and 'Гүйлгээ хийх' (Make Payment) for each account.

Дэлгэрэнгүй товч дээр дарснаар Дансны дэлгэрэнгүй жагсаалт хэсэгт шилжинэ.


Тухайн данснаасаа гүйлгээ хийх боломжтой.

Тухайн дансны хуулга авах боломжтой.

Зээлийн график харж, зээл төлөлтийн гүйлгээ хийх боломжтой.

## 2.2. Сүүлийн 5 гүйлгээ


Та гүйлгээний электрон баримтыг дахин хэвлэж авахыг хүсвэл Сүүлийн И-Гүйлгээ хэсгийг ашиглах боломжтой



Дэлгэрэнгүй товч дээр дарснаар Гүйлгээний түүх хэсэгт шилжинэ.


Дэлгэрэнгүй товч дээр дарснаар тухайн гүйлгээнийхээ баримтыг хэвлэн авах боломжтой.

Та баримт хэвлэх товч дээр дарж тухайн гүйлгээний баримтыг хэвлэн авч болно.




Та гүйлгээний баримтыг и-мэйл хаяг руугаа авч болно.

## 2.3. Түгээмэл хийгддэг гүйлгээнүүд



Гүйлгээ хийх товч дээр дарж тухайн гүйлгээг хуулан дахин гүйлгээ хийх боломжтой.

## 2.4. Гүйлгээний загварууд




Тухайн загвар гүйлгээг устгах боломжтой.

Гүйлгээ хийх товч дээр дарж өмнө нь загвар болгон хадгалсан гүйлгээг дахин хийхэд ашиглана.

## 3. ДАНС

### 3.1. Дансны жагсаалт

Та энэхүү цэсээр Интернэт банк үйлчилгээнд бүртгэлтэй дансны мэдээллээ бүрэн харах боломжтой.



ХАРИЛЦАХ ДАНС	Дансны дугаар	Дансны төрөл	Боломжит үлдэгдэл	Нийт үлдэгдэл
1001000027/RUB	ИРГЭДИЙН ХАРИЛЦАХ ЭНГИЙН ДАНС		968.03	1,118.03
1001000028/USD	ДЕБИТ АЛТАН КАРТ		255.87	260.87
1001000029/CNY	ИРГЭДИЙН ХАРИЛЦАХ ЭНГИЙН ДАНС		4,149.78	4,249.78
5101000387/MNT	ЦАЛИНГИЙН ДЕБИТ КАРТ		1,240,782.85	1,245,782.85


ХАДАГАЛМЖИЙН ДАНС	Дансны дугаар	Зээлийн төрөл	Зээлийн үлдэгдэл	Хуримтлагдсан хүү
ЗЭЭЛИЙН ДАНС	100400407/MNT	ЦАЛИНГИЙН ЗЭЭЛ АЖИЛТАНД	4,783,094.8	

Тухайн дансны ард байрлах хуулга авах, гүйлгээ хийх товч байхаас гадна данс нуух товч байх ба үүгээр сонгосон дансыг харагдахгүй болгох, гүйлгээ хийх үед харагдуулахгүй болгох боломжтой.

Тухайн дансны дугаар дээр дарснаар дэлгэрэнгүй мэдээллээ харах боломжтой.

### 3.2. Хуулга авах

Дансны хуулга авахдаа та “Хуулга харах” товч дээр дарж хүссэн хугацааны хооронд хийгдсэн гүйлгээгээ харах, хэвлэх боломжтой. Мөн дансны хуулгаа PDF, XLS хэлбэрээр хадгалж болно.



Дансны хуулга | 1001000028/USD - ДЕБИТ АЛТАН КАРТ

Данс: 1001000028/USD - ДЕБИТ АЛТАН КАРТ

Эхлэх огноо: 2018.08.01


Дуусах огноо: 2018.08.15

Хуулга харах

1001000028/USD - ДЕБИТ АЛТАН КАРТ
1001000030/USD - ИРГЭДИЙН ТУСГАЙ ХАРИЛЦАХ ДАНС 3 CAP
1001000036/MNT - /ХШЕН-С ӨӨР/ - ИРГЭДИЙН ТУСГАЙ ХАРИЛЦАХ ДАНС 13-36 CAP
1004000407/MNT - ЦАЛИНГИЙН ЗЭЭЛ АЖИЛТАНД
1008000184/MNT - ОУ-Н ЭРХТЭЙ АЛТАН КРЕДИТ КАРТ
1008000185/USD - ОУ-Н ЭРХТЭЙ ЭНГИЙН КРЕДИТ КАРТ
5101000387/MNT - ЦАЛИНГИЙН ДЕБИТ КАРТ

### 3.3. Зээлийн график

Зээлийн графикаас та зээлийн тогтмол төлөх төлбөрийн дүнг харах ба төлбөр төлөгдсөн бол ногоон өнгөтэй харагдана.



№	Огноо	Үндсэн зээл	Хүү	Нийт төлбөр	Хуваарьт үлдэгдэл
1	2018-02-23	112,308.32	62,136.99	174,445.31	6,887,691.68
2	2018-03-09	126,891.93	47,553.38	174,445.31	6,760,799.75
3	2018-03-23	127,768.01	46,677.3	174,445.31	6,633,031.74

## 4. ГҮЙЛГЭЭ

Та интернэт банкны Гүйлгээ цэснээс дараах үйлчилгээг авах боломжтой. Үүнд:

- Өөрийн данс хооронд гүйлгээ хийх
- Банк доторх гүйлгээ хийх
- Банк хооронд гүйлгээ хийх
- Гадаад шилжүүлэг хийх
- Зээл төлөх
- Гүйлгээний түүх

Харилцагчийн өдөрт хийх гүйлгээний лимит:


- Гүйлгээний нууц үгээр гүйлгээ хийх лимит 3 сая төгрөг, түүнтэй тэнцэх валют
- ОТР(one time password-нэг удаагийн нууц үг) ашиглан гүйлгээ хийх лимит 15 сая төгрөг, түүнтэй тэнцэх валют
- Өдрийн гүйлгээ хийх дээд лимит 15 сая төгрөг, түүнтэй тэнцэх валют

ОТР буюу Нэг удаагийн нууц үгийг гар утасны **CKBANK** аппликэйшнээр үүсгэн гүйлгээ хийж болно. Нэг удаагийн нууц үг нь 60 секундын хугацаанд ашиглах боломжтой ба энэ хугацаанд амжаагүй бол дахин үүсгэж авна.



#### 4.1. Өөрийн данс хооронд

Өөрийн данс хооронд гүйлгээ хийх тохиолдолд хүлээн авагчийн дансны дугаарыг бичих шаардлагагүй ба жагсаалтаас сонгоно.



The screenshot shows the 'Transfer' (Гүйлгээ) screen in the mobile app. At the top, there are navigation icons for Home (Эхлэл), Accounts (Данс), Transfer (Гүйлгээ), and Payments (Бүтээгдэхүүн). The user's name 'Д. СОЛОНГО' and IP address 'Таны IP: 172.17.11.5' are visible in the top right. Below the navigation bar, there are tabs for 'Өөрийн данс хооронд' (Inter-account), 'Банк дотор' (Within bank), 'Банк хооронд' (Between banks), 'Гадаад шилжүүлэг' (International), and 'Зээл төлөх' (Pay loan).

The main section is titled 'Өөрийн данс хооронд шилжүүлэг хийх' (Perform inter-account transfer). It includes a progress indicator with three steps: '1. Гүйлгээ шивэх' (Transfer), '2. Баталгаажуулах' (Confirm), and '3. Гүйлгээ хийгдээгүй' (Transfer not completed). The screen is divided into two columns: 'ШИЛЖҮҮЛЭГЧ' (Sender) and 'ХҮЛЭЭН АВАГЧ' (Receiver).

**Sender (ШИЛЖҮҮЛЭГЧ) details:**  
 - Card: 5101000387 ЦАЛИНГИЙН ДЕБИТ КАРТ | M...  
 - Balance: Боломжит үлдэгдэл 1,240,782.85 MNT  
 - Currency: MNT  
 - Amount: (empty field)  
 - Recipient: (empty field)

**Receiver (ХҮЛЭЭН АВАГЧ) details:**  
 - Card: 1001000028 ДЕБИТ АЛТАН КАРТ | USD  
 - Currency: USD  
 - Amount: (empty field)

At the bottom, there is a checkbox for 'Гүйлгээг загвар болгон хадгалах' (Save transfer as template) and a field for the recipient name 'Өөрийн данс хооронд'. A blue 'Үргэлжлүүлэх' (Continue) button is located at the bottom right. An 'Activate Windows' watermark is visible in the bottom right corner.


Хэрэв гүйлгээг загвар болгон хадгалах бол “Гүйлгээг загвар болгон хадгалах” сонголтыг хийж үргэлжлүүлэх товч дарна.

Гүйлгээ хийх мэдээллүүдийг үнэн зөв оруулж “Үргэлжлүүлэх” товчийг дарж гүйлгээний нууц үг хийж баталгаажуулах хэсэгт шилжинэ.


Гүйлгээний нууц үгээ оруулж үргэлжлүүлэх товч дарснаар Гүйлгээ амжилттай хийгдсэн талаарх мэдээлэл гарах бөгөөд амжилттай болсон тохиолдолд таны бүртгэлтэй и-мэйл хаяг руу электрон баримт илгээгддэг.

## 4.2. Банк доторх гүйлгээ

Чингис хаан банкны данс хооронд гүйлгээ хийхэд хүлээн авагчийн дансны дугаарыг оруулсанаар хүлээн авагчийн овог нэр нууцлагдсан байдлаар харагдах ба зөв эсэхээ шалгасны дараа гүйлгээгээ баталгаажуулна уу.




Хэрэв гүйлгээг загвар болгон хадгалах бол “Гүйлгээг загвар болгон хадгалах” товчийг дарж үргэлжлүүлэх товч дарна.



Гүйлгээний нууц үгээ оруулж үргэлжлүүлэх товч дарснаар Гүйлгээ амжилттай хийгдсэн талаарх мэдээлэл гарах бөгөөд амжилттай болсон тохиолдолд таны бүртгэлтэй и-мэйл хаяг руу электрон баримт ирнэ.

### 4.3. Банк хоорондын гүйлгээ


Банк хооронд гүйлгээ хийхдээ та хүлээн авагчийн банк, хүлээн авагчийн дансны дугаар, нэрийг зөв оруулах шаардлагатай ба төгрөгийн бага дүнтэй (0-1,000,000 хүртэл) гүйлгээ бодит цагийн горимоор буюу шууд хүлээн авагчийн дансанд орно. Төгрөгийн их дүнтэй (1,000,001 төгрөгөөс дээш) гүйлгээ ажлын өдрүүдийн 9:00-16:00 цагийн хооронд илгээгддэг ба тухайн өдрийн 16 цагаас хойш шилжүүлсэн гүйлгээ дараагийн ажлын өдөр шилжих болохыг анхаарна уу!



Bank transfer form details:

- Шилжүүлэгч:** Шилжүүлэх данс: 5101000387 ЦАЛИНГИЙН ДЕБИТ КАРТ | М. Боломжит үлдэгдэл 1,276,037.85 MNT
- Хүлээн авагч:** Хүлээн авагчийн банк: УЛААНБААТАР ХОТЫН БАНК
- Хүлээн авагчийн данс:** 2600046494
- Хүлээн авах дүн:** 20,000 MNT
- Хүлээн авагчийн нэр:** Баярмаа

Хэрэв гүйлгээг загвар болгон хадгалах бол “Гүйлгээг загвар болгон хадгалах” сонголтыг хийж үргэлжлүүлэх товч дарна.




Transaction Summary:

Шилжүүлэгч	Хүлээн авагч
Шилжүүлэх данс: 5101000387	Хүлээн авах банк: УЛААНБААТАР ХОТЫН БАНК
Шилжүүлэх дүн: 20,000 MNT	Хүлээн авах данс: 2600046494
Гүйлгээний утга: шилжүүлэг	Хүлээн авах дүн: 20,000 MNT
	Хүлээн авагчийн нэр: Баярмаа

Гүйлгээний нууц үгээ хийн үргэлжлүүлэх товч дарснаар Гүйлгээ амжилттай хийгдсэн талаарх мэдээлэл гарах бөгөөд амжилттай болсон тохиолдолд таны банканд бүртгэлтэй и-мэйл хаяг руу электрон баримт ирнэ.

#### 4.4. Гадаад шилжүүлэг

СВИФТ сүлжээг ашиглан бусад улс руу үндсэн валютаар /USD, EUR, RUB, CNY/, төгрөг, ам.долларын эсрэг хөрвүүлж /GBP, AUD, CAD, KRW/ гадаад шилжүүлэг хийнэ.



**Гадаад шилжүүлэг хийх**

1. Гүйлгээ шарах    2. Баталгаажуулах    3. Гүйлгээ хийгдэгүй

**ШИЛЖҮҮЛЭГЧ**    **ХҮЛЭЭН АВАГЧ**

Шилжүүлэх данс: 5101000387 ЦАЛИНГИЙН ДЭБИТ КАРТ / MNT    Боломжтой үндэс: 1,276,037.85 MNT

Гүйлгээний дүн: 1,000,000 MNT

Гүйлгээний утга: гадаад гуйвуулга

Шилжүүлэгчийн нэв: Улаанбаатар 14251, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 15, Нью Сенчаори Плаза

Данс / IBAN нөд: \_\_\_\_\_

Хүлээн авагч дүн: \_\_\_\_\_

Хүлээн авагчийн нэр: \_\_\_\_\_

Хүлээн авагчийн хаяг: \_\_\_\_\_

Хүлээн авагчийн улс: \_\_\_\_\_

**ХҮЛЭЭН АВАГЧ БАНК**

Банкны нэр: \_\_\_\_\_

Хүлээн авагч банкны хаяг: \_\_\_\_\_

Банкны код: \_\_\_\_\_

Свифт код: \_\_\_\_\_

Дамжуулагч банкны мэдээлэл: \_\_\_\_\_

Төлбөрийн зориулалт: \_\_\_\_\_

Шимтгэлийн нөхцөл: \_\_\_\_\_

Гүйлгээг загаар болгон хадгалах:

Загварын нэр: \_\_\_\_\_

**Ургалжлуулах**

Уг мэдээллийн хэсгийг бөглөхдөө хүлээн авагчийн холбоотой дээрх мэдээллүүдийг мэдэж байх шаардлагатай ба энэхүү гүйлгээ нь Чингис хаан банкны гадаад төлбөр тооцооны ажилтан руу илгээгдэж бүх мэдээлэл шалгагдсаны дараа цааш дамжуулагддаг.


Хүлээн авагчийн банкны нэр, хаяг, СВИФТ кодыг заавал бичих шаардлагатай ба хэрэв та мэдэхгүй тохиолдолд [www.swift.com](http://www.swift.com) хаягнаас кодтой эсэхийг лавлан харах боломжтой.

Гадаад руу хийх гуйвуулгын гүйлгээтэй холбоотой асууж тодруулах зүйл байвал Чингис хаан банкны Мэдээллийн төвий 1800-1300 утсаар банктай холбогдоно уу.


#### 4.5. Зээл төлөх

Зээл төлөх хэсгээр бүх төрлийн зээл болон кредит картынхаа зээлийн төлбөрийг хийнэ.

Харилцагч та зээл төлөх данс, зээл төлүүлэх дансаа сайтар нягтлах хэрэгтэй.




Оруулсан мэдээллээ шалгасны дараа үргэлжлүүлэх товчийг дарж гүйлгээний нууц үгийн баталгаажуулалт хэсэгт шилжинэ.



Гүйлгээ амжилттай хийгдсэн эсэх мэдээлэл гарах бөгөөд амжилттай хийгдсэн тохиолдолд харилцагчийн и-мэйл хаяг руу электрон баримт ирнэ.


## 4.6. Гүйлгээний түүх

Гүйлгээний түүх цэснээс интернэт банкаар хийсэн бүх гүйлгээний баримтыг и-мэйл хаягаар болон хэвлэн авч болно.



Гүйлгээний огноо	Шилжүүлэгч данс	Шилжүүлсэн дүн	Хүлээн авах данс	Хүлээн авагчийн нэр	Гүйлгээний утга
2018-08-16, 11:04	5101000387/MNT	2,000.0 MNT	2600046494/MNT	bayarmaa	f
2018-08-16, 11:03	1001000028/USD	0.01 USD	1001000027/RUB	СОЛОНГО ДЭЛГЭРЦЭЦЭГ	test

Тухайн гүйлгээг бүртгэлтэй и-мэйл хаяг руу авах, хэвлэн авах товч




Тухайн гүйлгээг хуулан гүйлгээ хийх товч

## 5. БҮТЭЭГДЭХҮҮН

Та бүтээгдэхүүн хэсгээс мессеж мэдээ, мессеж банк, интернэт банк, социал банкны “Шимтгэл хураамж, ашиглах заавар, санамж”-тай танилцаж болно.


Мессеж мэдээ хэсгийн “Тохируулах” товчийг дарж өөрийн дансны орлого, зарлагын мэдээг тохируулах боломжтой. Та мессеж авах дугаар, шимтгэл авах дансны дугаарыг оруулан хадгалсанаар зөвхөн тухайн данснаас шимтгэл авах болохыг анхаарна уу.



Шимтгэл авах дансны дугаар, мессеж мэдээ авах утасны дугаарыг тохируулан Хадгалах товч дарна

Орлого, зарлагын мэдээг тухайн дансан дээр тохируулан Хадгалах товч дарна.



## 6. ТОХИРГОО



Тохиргоо цэсээр та өөрийн хувийн мэдээллийг засварлах боломжтой

### 6.1. Хувийн мэдээлэл


Хувийн мэдээлэл хэсэгт нэвтрэх нэр, утасны дугаар, и-мэйл хаягийг солино.



Та нэвтрэх нэр солихдоо нэрний ард байрлах засах товч дээр дарж нэрээ солино.

### 6.2. Нууц үг солих

Нууц үг солих цэсээр Нэвтрэх болон гүйлгээний нууц үгийг солих боломжтой.



Санамж: Аюулгүй байдлын үүднээс 2 сардаа нэг удаа нууц үгээ сольж байх хэрэгтэй.

Санамж2: Та шинээр нууц үг оруулахад:

**Улаан** – Bad – Шаардлага хангахгүй / Зөвхөн үсэг, тоо /

**Бүдэг ногоон** – Middle – Дунд зэргийн нууцлал / Том үсэг, тоо /

**Тод ногоон** – Good – Баталгаатай нууцлал / Том үсэг, тоо, тэмдэгт /

### 6.3. Нууц асуулт хариулт солих


Нууц асуулт хариултаар нэвтрэх үйлдлийг идэвхижүүлснээр таны дансны нууцлал давхар нэмэгдэх давуу талтай.

**“Цаашид асуултаар баталгаажуулах”** гэдгийг идэвхижүүлснээр та нэвтрэхдээ нэвтрэх нууц үгээ хийж баталгаажуулсаны дараа өөрийн тохируулсан нууц асуултандаа давхар хариулж нэвтэрнэ гэсэн үг юм.


Нууц асуулт нь системээс асууж буй сонголтод асуулт, өөрийн нууц асуултаа оруулах гэсэн 2 сонголттой. Өөрийн оруулсан нууц асуултаа устгаж өөрчилж болно.

Нууц асуулт хариултаар давхар нэвтрэхийг хүсвэл идэвхижүүлэн нууц асуулт, хариултаа оруулан хадгална.

Нууц асуулт хариултаар нэвтрэхийг хүсэхгүй бол идэвхигүй болгон хадгална.



Нууц асуулт хариултаар нэвтрэх үйлдлийг идэвхижүүлснээр **“Нэвтрэх нэр, нууц үг”** оруулж **Нэвтрэх** товч дарсны дараа таны тохируулсан Нууц асуулт гарч ирэх ба хариултаа бичин баталгаажуулснаар амжилттай нэвтэрнэ.



Нууц асуултын хариултыг мартсан тохиолдолд **Хариултаа мартсан** товч дээр дарж банканд бүртгэлтэй и-мэйл хаягтаа нууц асуулт хариултыг дахин авч болно.

*Санамж: Та нууц асуулт хариултаа оруулахдаа бусад хүмүүс таах, мэдэх боломжгүй, зөвхөн өөрөө хариулах боломжтой асуулт хариулт оруулах нь тохиромжтой.*



## 6.4. Хандалтын түүх


Та өөрийн интернэт банк руу хандсан хугацаа, төхөөрөмжийн төрөл, IP хаягийг харж хянах боломжтой.

Хувийн мэдээлэл	Нууц үг солих	Нууц асуулт солих	Хандалтын түүх	
Хандалтын түүх			← Бүцэх	
Огноо	Төхөөрөмж	Үйлдлийн систем	Хөтөч	IP
2018-08-06, 08:12	Computer	Windows 10	Chrome 68.0.3440.84	172.17.11.5
2018-08-06, 08:46	Computer	Windows 10	Chrome 68.0.3440.84	172.17.11.5
2018-08-06, 09:41	Phone/iPhone	Unknown OS	Unknown Browser	10.10.10.8


## 7. ШУУРХАЙ ЦЭС




Та өөрт хэрэгтэй үйлдлээ хялбар гүйцэтгэх боломжтой туслах цэснүүд юм.




Интернэт банк ашиглах хэл солих товч



Та банктай холбоо барих бол тухайн товч дээр дарсанаар банк руу дуудлага хийгдэнэ.



Та өнөөдрийн Валютын ханшны мэдээллийг авч болно.



Интернэт банкнаас гарахыг хүсвэл энэхүү товчийг ашиглана.

## 8. САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Таны хийсэн гүйлгээний мэдээлэл банканд бүртгүүлсэн и-мэйл хаягт гүйлгээ хийсэн тухай бүрт “Электрон төлбөрийн баримт” нэртэйгээр очих бөгөөд шалгаж хянах боломжтой.
- Та нууц үгээ 3 удаа буруу оруулсан тохиолдолд хэрэглэгчийн нууц үг блоклогдох, нэвтрэх нууц үг, гүйлгээний нууц үгээ мартсан тохиолдолд та бичиг баримтын хамт өөрийн биеэр банканд дээр очих эсвэл манай банкны Мэдээллийн төвийн 1800-1300 дугаарт холбогдож авах боломжтой.
- Танай байгууллагын мэдээлэлд өөрчлөлт орсон даруйд банканд дээр албан бичгийг эрх бүхий ажилтан авчирч мэдээллийн санд өөрчлөлт оруулж байхыг анхаарна уу.
- Интернет банкны үйлчилгээнд холбогдсон идэвхигүй 10 минутын хугацааг систем автоматаар хянаж хэтэрсэн хугацаанд “Гарах” төлөвт шилжинэ.
- Интернет банкнаасаа гарахдаа аюулгүй байдлын үүднээс “Системээс гарах” товч дээр дарж хэвшинэ үү.

### ХОЛБОО БАРИХ:

**Вэб сайт:** [www.ckbank.mn](http://www.ckbank.mn)  
**И-мэйл хаяг:** [ebank@ckbank.mn](mailto:ebank@ckbank.mn)  
**Утас:** 1800-1300

**Байршил:** Улаанбаатар 14251,  
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн  
чөлөө 15, Нью Сенчьюри Плаза